

2008.01.31

Дугаар10

“Хаан банк” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.3, 8.2.4, 8.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Хаан банк” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

2.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, Хорооны шийдвэрийг Улсын бүртгэлийн алба болон олон нийтэд мэдээлж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ